

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ 2 ДУГААР САРЫН МЭДЭЭ

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

1.1. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны мэдээлэл

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаан 2 дугаар сард хийгдээгүй.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдэд нөхөн олговор олгох хүрээнд 1 хүний материалыг сонинд зарлуулсан. Хилс хэрэгт хэлмэгдэгчдийн үр хүүхдүүдэд нийт 720,000,0000 төгрөг олгосон.

Аймаг байгуулагдсаны 80 жилийн ойн арга хэмжээнд аймгийн ИТХ-ын ажлын албаны ажилтнууд нэг өдрийн цалинг хандивлав.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд иргэд, байгууллага, аж ахуйн нэгжээс 26 аялал бичиг ирсэн бөгөөд аймгийн ИТХ-аас 33 аялал албан бичиг явуулж, иргэдийн биечлэн болон бичгээр өргөдөл хэргийг холбогдох газарт уламжилж, шийдвэрлэх боломжтой асуудлыг тухай бүрт нь шийдвэрлэсэн.

Мөн 2 дугаар сарын байдлаар нийт 19 өргөдөл, гомдол ирснээс ажил хүсэх тухай 13, тусламж хүсэх тухай 1, хүсэлт тавих тухай 3, чөлөө хүсэх тухай 1, гомдол гаргах тухай 1 өргөдөл тус тус ирсэн байна. Өргөдлийг хуулийн дагуу холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлэн албан бичгээр уламжлав.

1.2. Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл

Аймгийн Удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн 2 дугаар сард нэг удаа хуралдсан ба Монгол Улсын хэмжээнд хэсэгчилсэн өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэнтэй холбогдуулан үйл ажиллагаагаа түр хугацаагаар зогсоосон.

Гадаад харилцааны асуудалтай холбоотой үндэсний болон дэд хөтөлбөрүүдийн биелэлт, үндэсний аюулгүй байдлын тайланг хуулийн хугацаанд гаргаж холбогдох дээд байгууллагуудад хүргүүлсэн. Мөн Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газрын гадаад харилцаа, хамтын ажиллагааны талаар 2019 онд хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг гаргаж Гадаад харилцааны яаманд хүргүүлсэн.

2 дугаар сарын 3-ны өдөр тус аймгийн Засаг дарга А.Гылымхан сумдын Засаг дарга нарын 2019 оны гэрээг дүгнэж, 2020 онд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ байгууллаа.

Гэрээ байгуулснаар сумдын Засаг дарга нар орон нутагтаа Засгийн газрын болон аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, улс, аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлж, нийгмийн чухал салбар болох боловсрол, эрүүл мэнд зэрэг төрийн үйлчилгээг иргэд, олон нийтэд түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх үүрэг хүлээв.

Мөн хууль тогтоомжийн хүрээнд ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах, үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, иргэдэд

хүргэх төрийн үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэн ажиллахыг үүрэг болгож гэрээнд тусгасан.

Шинэ коронавирусын дэгдэлт, түүнээс урьдчилан сэргийлэх хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Засгийн газрын 30 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 2 дугаар хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор 2 дугаар сарын 4-ний өдөр аймгийн Засаг дарга А.Гылымхан "Зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай" А/61 тоот захирамж гаргаж, уламжлалт сар шинийн баярыг зөвхөн гэр бүлийн хүрээнд тэмдэглэн өнгөрүүлэхийг ард иргэдэд уриалав.

Мөн бүх шатны төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, нутгийн зөвлөл, хамт олны зохион байгуулалттай золголт хийхгүй байх, Цагаан сарын үндэсний бөхийн барилдаан, хурдан морины уралдаан зохион байгуулахгүй байхыг сумдын Засаг дарга нарт болон мэргэжлийн байгууллагын удирдлагуудад үүрэг болгож, зоогийн газар, караоке, баар, цэнгээний газар зэрэг үйлчилгээний байгууллагуудын цагийн хуваарьт 3-р сарын 2-ны өдөр хүртэл хязгаарлалт хийж, оройн 22:00 цаг хүртэл ажиллуулах тухай захирамж гаргав.

"Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг" Баян-Өлгий аймагт 2019 оны 9 дүгээр сард явагдсан ба энэхүү 4 жил тутамд нэг удаа зохион байгуулдаг тус улсын үзлэгээр албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа, байгууллагын архивын үйл ажиллагаа, байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтөд мэдээллийн технологи нэвтрүүлэх, цахим сан бүрдүүлэх үйл ажиллагаа, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт гэсэн 4 үндсэн чиглэлээр шалгуулж, нийлбэр дүнгээр 21 аймгаас 5 дугаар байрт шалгарсан.

Баян-Өлгий аймгийн Нэгдсэн эмнэлэгт энэ сарын 11-ний өдөр Шинэ коронавирусийн сэжигтэй нэг хүнийг тусгаарлаж, шинжилгээний дээжийг Халдварт өвчин судлалын үндэсний төв /ХӨСҮТ/ -д хүргүүлсэн ба ХӨСҮТ-ийн Ерөнхий захирал Д.Нямхүү Баян-Өлгий аймагт тусгаарлагдсан хүмүүсээс шинэ коронавирусийн халдвар илрээгүй буюу шинжилгээний хариу нь сөрөг гарсан тухай мэдэгдсэн.

Баян-Өлгий аймагт коронавирусын сэжигтэй тохиолдол илэрсэнтэй холбогдуулан аймгийн Онцгой комисс 2020 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн шөнийн 03:00 цагт шуурхай хуралдаж холбогдох шийдвэрүүдийг гаргав. Үүнд Аймгийн Засаг дарга тус аймагт коронавирусын сэжигтэй тохиолдол илэрсэнтэй холбогдуулан хязгаарлалтын арга хэмжээ авах тухай А/84 тоот захирамж гаргаж, Өвчтөнтэй хавьтал болсон иргэдийг орон гэрт нь тусгаарлаж хамгаалалтад авах, "Тирлик", "Ахдам" захуудын үйл ажиллагааг шинжилгээний хариу гартал түр хязгаарлаж, Баар, ресторан, зоогийн газар, кафе, караоке, сүм хийдүүдийн үйл ажиллагааг 2020 оны 3 дугаар сарын 2-ныг хүртэл түр хугацаагаар зогсоох, Авто замын хяналтын постын үйл ажиллагааг эрчимжүүлэн, ирэх зорчигчдын тандалт судалгааг тогтмол хийж, МХГ, ОБГ, ЦГ, МЭГ-аас хүч нэмэгдүүлэн ажиллах зэрэг үүрэг өгсөн.

Жил бүр Монгол Улсын Засгийн газраас сар шинийн өмнө Улсын аварга малчин, Улсын аварга тариаланчдыг шалгаруулдаг уламжлалтай.

Энэхүү уламжлалын дагуу Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр Баян-Өлгий аймгаас улсын хошой аварга малчин 1, улсын аварга малчин 7, улсын аварга тариаланч 2, улсын аварга тариаланч хамт олон 1 тодров.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 10 дугаар зарлиг, Монгол Улсын Засгийн газрын "Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай" 2020

оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 62 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын даргын “Төлөвлөгөө батлах тухай” 2020 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 04 дүгээр тушаалыг хэрэгжүүлэх, шинэ төрлийн коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга А.Гылымхан “Ажлын тусгай горимд шилжүүлэх тухай” А/239 дугаар захирамж гаргав.

Үүнд Засгийн газрын 2020 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 62 дугаар тогтоолоор гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэнтэй холбогдуулан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, орон нутгийн гамшгаас хамгаалах алба, хуулийн этгээдүүдийг ажлын тусгай горимд шилжүүлэн ажиллуулах, Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчлэн шилжсэнтэй холбогдуулан шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангах үүрэг бүхий аймгийн Шуурхай штаб байгуулахыг Засаг даргын Тамгын газар, орон нутгийн гамшгаас хамгаалах алба, сумдад мөн адил Шуурхай штаб байгуулж, хүч хэрэгслийг томилгоожуулан бэлтгэл, бэлэн байдлыг хангаж ажиллахыг орон нутгийн гамшгаас хамгаалах алба, сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгов.

Баян-Өлгий аймгийн Засаг даргын 2020 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн А/99 тоот захирамжаар томилогдсон шуурхай штабыг аймгийн Засаг даргын Тамгын газарт байгуулж, 24 цагаар үүрэг гүйцэтгэн, Зооноз өвчин судлалын төв, Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Авто тээврийн төв зэрэг мэргэжлийн байгууллагаас байнгын жижүүр ажиллаж 70427049 дугаарын утсаар мэдээ мэдээлэл хүлээн авч, удирдлагаар ханган ажиллаж байна.

“Баян-Өлгий аймагт жүдо бөхийн спортыг хөгжүүлэх, шинэ түвшинд гаргах, бүс, улс, олон улсын дэвжээнд аймаг, улсын нэрийг гаргах тамирчдыг бэлтгэх зорилго бүхий хамтын ажиллагааны санамж бичигт энэ сарын 17-ны өдөр аймгийн Засаг дарга А.Гылымхан аймгийн Жудо бөхийн холбооны тэргүүн Х.Мухтар нар гарын үсэг зурж баталгаажууллаа.

Энэ сарын 21-ний өдөр Баян-Өлгий аймгийн Онцгой комиссын 6 дугаар хуралдаан 93.5%-ийн ирцтэй хуралдаж аймаг, сумын төвөөс гарах, орох хөдөлгөөнийг түр хугацаагаар зогсоох шийдвэр гаргалаа.

Тодруулбал "Улсын Онцгой комиссын 2020 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 5 дугаар хурлын шийдвэр, Зам, тээврийн сайдын 2020 оны А/48 тоот тушаалыг тус тус үндэслэн коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд цагаан сарын баярын өдрүүдээр аймаг, сумын төвөөс гарах, орох хөдөлгөөнийг 2020 оны хоёрдугаар сарын 23-ны өдрийн 08:00 цагаас 27-ны өдрийн 08:00 цаг хүртэл түр зогсоох тухай аймгийн Засаг даргын А/113 дугаар захирамж гарав.

Мөн 2 дугаар сарын 26-ны өдрийн 15:00 цагт аймгийн Онцгой комисс 100%-ийн ирцтэй хуралдаж, аймаг, сумын төвөөс гарах, орох хөдөлгөөнийг 2 дугаар сарын 27-ны 08:00 цагаас 3 дугаар сарын 03-ны өдрийн 08:00 цаг хүртэл зогсоох шийдвэр гаргав.

2020 оны 2 дугаар сарын 25-ны өдөр Баян-Өлгий аймагт "Хүннү эйр" компанийн Улаанбаатар-Өлгий чиглэлийн онгоцоор ирсэн Монгол Улсын нэг, Вьетнам улсын дөрвөн иргэнийг тусгаарлалаа.

Тодруулбал онгоцонд 27 зорчигч байсан ба Вьетнам улсаас дөрвөн жуулчин, БНСУ-д суралцдаг тус аймгийн нэг оюутан онгоцоор Өлгий хотод 16 цаг 44 минутад газардсан байна.

Дээрх таван иргэнийг аймгийн Нэгдсэн эмнэлэгт тусгаарлаж, хамт зорчиж ирсэн 23 иргэнийг бас хяналтад авсан ба зорчигчдыг тээвэрлэж ирсэн агаарын хөлөгт ариутгал, халдваргүйжүүлэлт хийсэн.

Шинжилгээний дээжийг авч, онгоцоор ХӨСҮТ-д хүргэж, хариу нь сөрөг гарсан болно.

1.2.1. Өргөдөл, гомдлын талаар

2020 оны 2 дугаар сард аймгийн Засаг даргын Тамгын газарт нийт 90 өргөдөл ирүүлснээс бичгээр 80, аймгийн ИТХ-аас 10 өргөдөл шилжүүлсэн байна.

Эдгээрээс 77 өргөдлийг хэлтэс, агентлагуудад шийдвэрлүүлэхээр уламжилсан, одоогоор шийдвэрлэх шатандаа явж байгаа ба 13 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэж иргэдэд хариу өгсөн болно.

Ирүүлсэн 90 өргөдлөөс:

- Ажил хүссэн 55
- Хүсэлт тавих тухай 13
- Гомдол 4
- Тусламж хүссэн 5
- Нэмэгдэл 1
- Эмчилгээний зардал хүссэн тухай 4
- Чөлөө 3
- Орон байр хүссэн тухай 1
- Тэтгэмж хүссэн тухай 1
- Цахилгаан шугам татуулах тухай 3 өргөдөл тус тус ирүүлсэн болно.

ХОЁР. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

2.1. Хууль хяналтын үйл ажиллагаа

2.1.1. Хууль, эрх зүйн хэлтсийн мэдээлэл

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс нь аймгийн Засаг даргын 72 ширхэг А захирамжийг хянаж, тус буюу хууль тогтоомжийн лавлах санд хууль, Улсын Их Хурлын болон Засгийн газрын тогтоол, эрх зүйн хэм хэмжээний актыг шинээр бүртгээгүй, иргэдээс амаар болон бичгээр гаргасан хүсэлт, өргөдлийг хүлээн авч, 4 хүнд зөвлөгөө өгч үйлчлэв. Мөн согтууруулах ундаа худалдах нөхцөл, шаардлагыг хангаж, улсын тэмдэгтийн хураамж төлсөн 15 дэлгүүр болон 2 үйлчилгээний газарт спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг 2 жилийн хугацаагаар шинээр зөвшөөрөл олгов.

1.Архивын тасгийн мэдээ.

Иргэдээс 230 өргөдлийг хүлээж авч, 3935 хадгаламжийн нэгжийг ашиглаж 231 лавлагаа, 787 хуудас баримтыг хуулбараар олголоо.

Харилцагч байгууллагуудаас 20 албан бичиг ирснээс 15 хугацаатай албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлж, байгууллагуудад 21 албан бичиг хүргүүлж ажиллав.

Баяннуур, Цэнгэл, Буянт, Алтай сумуудаас 2000-2018 оны мал тооллогын баримтуудыг хүлээн авлаа.

Байгууллагуудын архив, албан хэрэг хариуцсан 11 хүнд зөвлөгөө өгөв.

Архивын тасгийн нийт цахимжуулсан баримтын мэдээг 2020 оны 2 дугаар сарын байдлаар Архивын ерөнхий газарт хүргүүлэв.

2.1.2. Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээлэл /өссөн дүнгээр/

1	Иргэдийн баримт бичгийн зөрчлийн арилгалт хувь	99,9
2	Шилжих хөдөлгөөн хот /шилжиж ирсэн аймаг хотоос/	52
3	Шилжих хөдөлгөөн хот дотор /сум, багаас/	699
4	Гадаад паспорт эзэмшигчдийн тоо	673
5	Шинээр гэрлэлт /тоо/	70
6	Нас баралтын бүртгэл	44
7	Төрсний гэрчилгээний бүртгэл	189
8	Үрчлэлт	26

2.1.3. Шүүхийн шинжилгээний албаны мэдээлэл

№	Үзүүлэлт	Тухайн сар	Өссөн дүн
1	Криминалистикийн шинжилгээний тоо	8	20
2	Хэргийн газрын үзлэгт оролцсон тоо	38	79
3	Гутлын мөр	14	25
4	Тээврийн хэрэгслийн мөр	7	14
5	Эвдлэгч багажийн мөр	0	-
6	Биологийн гаралтай ул мөр	2	4
7	Бусад ул мөр	7	47
8	Хонгио хошуу	20	20
9	Гарын дардас	54	64
10	Гарын мөр	2	15
11	Шүүх эмнэлгийн хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээний тоо	31	109
12	Шүүх эмнэлгийн бэлгийн холбогдолтой шинжилгээний тоо	2	3
13	Цогцост хийсэн шинжилгээний тоо	1	6
14	Тусгай шинжилгээ болон химийн шинжилгээний тоо	8	16

2.2. Мэргэжлийн хяналтын чиглэлээр

Заалт	Биелэлт, хувь тоо
Хяналт шалгалтад хамрагдсан байгууллага, илрүүлсэн зөрчил	Нийт 41 байгууллагад хяналт-шалгалт хийсэн.
Зөрчил дутагдлын барагдуулалт	Зөрчлийн барагдуулалт 70%-тай байна
Оногдуулсан торгууль, шийтгэврийн барагдуулалт	Нийт бүртгэгдсэн зөрчлийн тоо 11 хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэсэн 11, 10 иргэн 1 аж ахуйн нэгжид нийт 2,000.0 мянган төргөгийн торгууль тавьж ажилласан байна.
Хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх талаар зохион байгуулсан сургалт арга хэмжээний үр дүн/тоо/	Албан хаагч нарын хуулийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор дотооддоо Хууль, эрх зүйч 3 удаа, Нисэх буудал, Авто тээврийн төв, Цагааннуурын боомт, Эрүүл мэндийн газар, ӨЭМТ-үүдэд шуурхай байдлын үед авах арга хэмжээний талаар 10 удаа сургалт зохион

	байгуулав.
Хуваарийн дагуу хариуцаж авсан эмзэг бүлгийн өрхөд чиглүүлэн зохион байгуулсан ажлын тоо	МХГ-аас тусламж хүссэн 2 иргэнд мөнгөн дүнгээр тусламж үзүүлсэн.

ГУРАВ. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

3.1. Эрүүл мэндийн чиглэлээр

Хот хоорондын, олон улсын тээврийн хэрэгсэл, агаарын тээврийн зорчигчдод аймгийн Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 36 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд 2 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн өдөр бүр хуваарийн дагуу онгоц, зам тээврийн постод 636 тээврийн хэрэгслээр орж гарсан 4479 зорчигчдод үзлэг хийж, биеийн халууныг хэмжиж, коронавирусын халдвараас сэргийлэх зөвлөгөө өгч ажилласан.

Орон нутгийн “Дербес”, “Саян”, ТВ4 телевиз болон 9 цагийн радиогоор цаг үеийн нөхцөл байдалтай холбоотой коронавирусын талаар 18 удаа цаг үеийн мэдээлэл өгсөн.

Эрүүл мэндийн салбарын Facebook хуудсанд коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх тухай 55 төрлийн мэдээлэл, зөвлөгөө оруулсан.

Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх Казах, Монгол хэл дээрх 3 төрлийн гарын авлага 510 ширхэг зурагт хуудсыг хэвлүүлэн аймгийн төвд үйл ажиллагаа явуулдаг албан байгууллага, зах, супермаркет, сумдад, аймгийн төвийн таксины жолоочид, Өлгий сумын 12 багийн Засаг дарга нарт тарааж, нийт 8000 гаруй иргэнд сургалт сурталчилгаа хийгдэж, 1458 тараах материал түгээсэн байна.

Аймгийн ЭМГ-ын Шуурхай штабт 99493103, 70422953 дугаартай 24 цагийн утсыг ажиллуулж иргэдэд зөвлөмж, мэдээлэл өгч байна.

Аймгийн төвд үйл ажиллагаа явуулдаг 28 эмийн санд 2 удаа үнийн судалгаа хийж амны хаалт, хамгаалах хувцас хэрэгслийн нөөцийн судалгааг гаргаж, эм ханган нийлүүлэх байгууллагуудын удирдлагуудтай уулзалт зохион байгуулж, үнийн хөөрөгдөл үүсгэхгүй байх талаар шаардлага хүргүүлэн хяналт хийгдэж байна.

Эрүүл мэндийн салбарт аймгийн Онцгой комиссын шийдвэрээр 55,4 сая төгрөгийн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, хувцсаар хангалт хийгдсэн.

Коронавирусын 2 удаагийн 6 сэжигтэй тохиолдолд тушаал зааврын дагуу ажиллаж, шинжилгээний хариу сөрөг гарсан. Өндөржүүлсэн бэлэн байдалтай ажиллаж байна.

3.2. Боловсрол, соёлын талаар

Шинэ коронавирусын дэгдэлттэй холбоотой аймгийн хэмжээний сургууль, цэцэрлэг, театр, номын сан, музей зэрэг байгууллагуудын үйл ажиллагааг түр зогсоосонтой холбогдуулан эдгээр байгууллагуудад өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар цогц үйл ажиллагаа хийгдэж плакат зурагт хуудас, гарын авлага тараасан.

Тус байгууллагуудад ариун цэвэр, халдваргүйжүүлэлтийн ажлыг тогтмол хийж байна.

БСШУС-ын сайдын тушаалаар батлагдсан “Теле” хичээлд хамрагдах заавар, зөвлөмжийн талаарх мэдээллийг орон нутгийн радио, телевиз мэдээллийн хэрэгслээр сурталчлав.

Сургуулийн эмч нарын бэлэн байдлыг хангах тухай аймгийн Засаг даргын захирамжийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

МСҮТ-ийн багш нарын санаачлагаар тус сургуулийн оёдлын цехээс маск оёж үйлдвэрлэн аймгийн нийгмийн эмзэг бүлгийн иргэдэд тарааж өгсөн.

ДӨРӨВ. ХӨДӨӨ, АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

4.Хөдөө аж ахуйн чиглэлээр

Тус аймгийн 13 суманд нийт 2,190,000 толгой мал өвөлжиж байна. 2019 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар хорогдол, хээл хаялт гараагүй. Мал аж ахуйн өвөлжилт хэвийн явагдаж байна.

Дэлхий даяар коронавирус өвчин гарсантай холбогдуулан аймгийн Мал эмнэлгийн газраас аймагт үйл ажиллагаа явуулж буй 6 махны үйлдвэрт ариутгал халдваргүйжүүлэлт хийв.

“Цагаан сар”-ын баярыг тохиолдуулан 13 сумаас аймгийн хошой аварга малчны болзол хангасан 10, аварга малчин өрхийн болзол хангасан 135, саальчны 6, тариаланчийн 8, анчны 10, фермерийн 1 бүгд 170 хүний материалыг хүлээн авч нэгтгэн журмын дагуу үнэлж байр эзлүүлэн аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд оруулав. 2020 онд аймгийн хошой аварга малчин өрх 9, аварга малчин өрх 111, саальчин 6, тариаланч 7, фермер 1, анчин 9 шалгарч Засаг даргын захирамж гаргав.

ХХААХҮЯамнаас өгсөн төлөвлөгөөний дагуу аймгийн газар тариалангийн салбарт 2020 онд тариалах талбай, хураах ургацын төлөвлөгөөг гаргаж тариалалтын бэлтгэл ажил хангуулах тухай аймгийн Засаг даргын А/124 тоот захирамж гаргаж бүх сумдад хүргүүлэв. 2020 онд аймгийн хэмжээнд 306 га-д төмс, 156 га-д хүнсний ногоо, 95 га-д жимс, жимсгэнэ, 700 га-д малын тэжээл тариалах төлөвлөгөө өгөгдөв.

Аймгийн Засаг даргын 2018 оны А/302, А/303 дугаар захирамжуудаар байгуулагдсан ажлын хэсгүүд болон аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газраас боловсруулан ирүүлсэн “Ноолуур”, “Эрчимжсэн мал аж ахуй”, “Жимс, жимсгэнэ”, “Хүнсний ногоо” болон “Үйлдвэржилт 13:13” аймгийн дэд хөтөлбөрүүдийн төслийг холбогдох удирдлагуудад танилцуулан тэдний саналыг тусган дахин боловсруулж уламжлав.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргын 2016-2020 үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргын болон ХХААГ-ын даргын ХХААХҮ-ийн сайдтай байгуулсан гэрээ, ХХААГ-ын даргын аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээ, Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримталж буй бодлого болон холбогдох бусад төсөл, хөтөлбөрүүдэд тусгагдсан зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх, тус газрын 2020 оны ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөг биелүүлэх зорилгоор удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг авч ажилласан.

Коронавирус болон томуу, томуу төстэй өвчний дэгдэлттэй холбоотой улс даяар онц байдал тогтоож байгаатай холбогдуулан аймгийн орон нутгийн хүнсний нөөцийн судалгааг гаргаж аймгийн Онцгой байдлын газарт хүргүүлэв.

ТАВ. БАЙГАЛЬ ОРЧИН, ҮЙЛДВЭРЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

5.1. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн чиглэлээр

2 дугаар сарын байдлаар сумдаас ирсэн 2019 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын тайланг нэгтгэж дуусган Сангийн яаманд хүргүүлэх ажлыг зохион байгуулж байна. Мөн 2019 оны сумдын орон нутгийн хөгжлийн индекс тооцох нийт 53 төрлийн тоон үзүүлэлтийг www.lidi.nda.mn цахим программд сум тус бүрээр шивж оруулах ажлыг гүйцэтгэж байна. 2020 оны төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

5.2. Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр

Менежмент хариуцагч “Монгол сафари” ХХК-тай хамтран Толбо сумын “Зурхайчин”, Бугат сумын “Тошинт Хатуугийн-гол”, “Төмөрт”, Улаанхус сумын “Агуйт хатуугийн гол” агнуурын бүс нутгуудад өвөлжиж буй ан амьтны өвөлжилтийн байдалтай танилцаж, өвс, давс, хужир тавьж био техникийн арга хэмжээ авах ажлуудыг зохион байгууллаа.

5 аж ахуйн нэгж, иргэдийн төслийн баримт бичигт байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргаж хүргүүлэв.

Өлгий хотын төвд хог шатааж байгаа албан байгууллагуудыг зурагжуулан албан шаардлага хүргүүлэн, хог хаягдлын тухай хуулийг сурталчлан, таниулах ажлыг зохин байгуулж байна.

Алтанцөгц сумын нутаг дэвсгэрээс зөвшөөрөлгүй 21.6 м3 түлээний мод бэлтгэсэн Ногооннуур сумын иргэнийг илрүүлэн хуулийн байгууллагад шилжүүлэн шалгуулж байна. Байгууллагын албан хаагчид "Хүрээлэн байгаа орчны эсрэг" гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулав.

Агаарын бохирдлын тооллогыг аймгийн хэмжээнд зохион байгуулж байна.

Аймгийн Засаг даргын 2019 оны А/239 дүгээр захирамж, аймгийн Онцгой комиссын 2020 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 1 албан тоотын дагуу 24 цагийн ажиллагаатай Шуурхай штаб байгуулан хариуцлагатай жижүүр ажиллуулж байна.

Орон нутгийн хэвлэл мэдээллээр Амьтны тухай хууль тогтоомжийг сурталчлах ажлыг 2 удаа, Ойн болон Усны тухай хууль тогтоомжийг сурталчлах ажлыг нэг удаа тус тус зохион байгууллаа.

Мод үржүүлгийн талбайн тарьц суулгацын нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор 2020 оны 2-р сарын 10-ны өдрөөс эхлэн Баяннуур сумын Цагаан арал багийн нутаг дэвсгэрийн ойгоос 15,000 ширхэг улиас модны саваа мөчир, 6,000 ширхэг бургас модны саваа мөчир, Бугат сумын Хатуугийн голын ойгоос 4000 ширхэг улиас модны саваа мөчир болон нийтдээ 25,000 ширхэг улиас бургас модны саваа мөчир бэлтгэж мод үржүүлгийн газрын зориулалтын зооринд технологийн дагуу хадгалах ажлыг хийж гүйцэтгэлээ.

5.3. Газрын харилцааны чиглэлээр

2 иргэний эзэмшил газрыг кадастрын шинэ зургийн дагуу худалдааны анхны үнэ болох 639000 төгрөгийг төлүүлэн өмнөх зориулалтаар нь эзэмшүүлэх тухай, 031302347 нэгж талбарын дугаартай 406 м2 газар, мөн 8312015314 нэгж талбарын дугаартай 450 м2 газруудын өмчлөх эрхийг дуусгавар болгож нийтийн орон сууцны

зориулалтаар барилга ашиглалтад орох хүртэлх хугацаатайгаар эзэмшүүлэх тухай, Өлгий сумын 13 дугаар багт байршилтай гэр бүлийн хамтын хэрэгцээний зориулалттай газар эзэмших эрхийн гэрчилгээг Өлгий сумын 11 дүгээр багийн иргэнд шилжүүлэн эзэмшүүлэх, 16 иргэнд 10679 м² газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлэх, өмчлүүлсэн газрын хэмжээнд өөрчлөлт оруулан 5 иргэнд 3496 м² газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлэх, 3 иргэнд газар өмчлөх эрх шилжүүлэн өмчлүүлэх тухай шийдвэрүүдийг тус тус гарсан.

Аймгийн хэмжээгээр 2020 оны газрын төлбөрийн ноогдуулалтыг цахим системд үүсгэх ажлыг дуусгав.

2020 оны 2 дугаар сарын 10-ний өдөр Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2020 оны 1 дүгээр сарын 30-ний өдрийн 1/273 тоот албан бичгийн дагуу Баян-Өлгий аймаг дахь Шинжлэх ухааны академийн Одон орон, геофизикийн хүрээлэнд байршуулсан GNSS-ийн байнгын ажиллагаатай станцыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, нэгдсэн сүлжээнд холбон станцын ажиллах горимыг нэг хэлбэрт оруулж, хэвийн ажиллагаа хангасан.

Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэхийг хүссэн 1, Газар эзэмших талбайн хэмжээг өөрчилж газар эзэмшихийг хүссэн 1 аж ахуйн нэгж байгууллагын хүсэлтийг холбогдох материалын хамт хүлээн авч аймгийн Засаг даргын захирамжийн дагуу гэрчилгээ олгож гэрээ байгуулан холбогдох өөрчлөлтийг Улсын бүртгэлд оруулсан. Мөн нэгж талбарын нөхөн бүрдүүлэлтийн ажлын хүрээнд Өлгий сумын газрын даамалтай хамтран 48 иргэний газар өмчлөх, эзэмших газрын кадастрын Лэндменежер програмд оруулсан.

“Өлгий ланд”, “Эл эм ланд” ХХК-ийн хийсэн 33 газрын хэмжилтийн мэдээллийг хүлээн авч кадастрын мэдээллийн санд оруулсан. Мөн сумдын даамлуудын үйлдэж өгсөн 23 газрын кадастрыг хянаж баталгаажуулсан.

5.4. Ус, цаг уур, орчны шинжилгээний чиглэлээр:

Коронавирусээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх аймгийн Засаг даргын 2020 оны А/44 дүгээр захирамжийг нийт ажилчдад танилцуулж хөдөөний ажилчдад цахимаар явуулав.

Коронавирусын эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр байгууллагын цэвэрлэгээ, ариутгалыг цаг тухайд нь хийж байна. Уг вирусээс урьдчилан сэргийлэх зорилгоор 7 хоногийн Даваа гараг болгон явуулах байгууллагын сургалтыг нийт ажилчдад цахимаар явуулж байна.

3 дугаар сарын урьдчилсан мэдээг холбогдох газруудад болон сумдад цахимаар хүргүүлэв.

Цаг агаарын урьдчилсан мэдээний талаар аймгийн радио болон телевизүүдэд ярилцлага өгөв. Мөсөн дээгүүр хүн, машин явахгүй байх талаар ард иргэд радиод сэрэмжлүүлэх мэдээ өгөв.

Баярын өдрүүдэд тус төвийн байранд хариуцлагатай жижүүр ажиллуулав.

5.5. Барилгын ажлын чиглэлээр

Цагааннуур тосгоны 100 ортой цэцэрлэг, аймгийн төвийн 100 ортой Нэгдсэн эмнэлгийн барилга, Улаанхус сумын төвийн эмнэлгийн барилгын өргөтгөл, Согоог багийн 160 хүүхдийн эмнэлгийн барилгуудын зураг төсвийг хянаж баталгаажуулсан.

Дэлүүн, Улаанхус сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дутуу санхүүжилт болох 99 сая төгрөгийн санхүүгийн материал, гүйцэтгэлийг гаргаж хүргүүлсэн. Аймгийн төвийн ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцнуудыг буулгах тооцоог гаргаж, холбогдох газарт хүргүүлсэн. Улсын болон орон нутгийн төсвөөр хийгдэх зарим их засварын ажлын схем, зураг төсвийг баталж өгсөн.

Цэнгэл сумын 100 ортой цэцэрлэг, Өлгий сумын Хотгор багын 20 ортой эмнэлэг, Ногооннуур сумын Ховд гол багийн 5 ортой эмнэлэг, Дэлүүн сумын хичээлийн А байрны их засварын схем, 100 хүүхдийн цэцэрлэгийн дээврийн их засварын схем зургийг тус тус баталсан.

5.6. Дэд бүтцийн чиглэлээр

5.6.1. Цахилгаан хангамжийн талаар

Аймгийн хэмжээнд Баруун бүсийн эрчим хүчний системээс 7065.0 мян.кВ.цаг цахилгааныг худалдан авч, 6254.0 мян.кВ.цаг цахилгаан худалдан борлуулсан. Нийт 931.0 мян.кВ.цаг цахилгааныг шугамд алдсан. Нийт алдагдал 13.2%-тай байгаа. Худалдан борлуулсан цахилгаанд 906.0 сая төгрөгийн нэхэмжлэл бичиж, 628.0 сая төгрөгийг цуглуулсан. Борлуулалтын орлого 69,32%-ийн цуглуулгатай байна.

5.6.2. Холбооны талаар

Энэ сард үндсэн сүлжээний төхөөрөмж, зай тэжээлийн болон шилэн кабелийн гэмтэл гараагүй. Аймгийн төвийн хэрэглэгчийн телефон цэгийн 13 гэмтэл гарч, хяналтын хугацаанд засварласан. Мөн кабел шугамаас гарсан гэмтлийг тухай бүх хяналтын хугацаанд нь засварлав.

5.6.3. Аймгийн радио телевизийн сүлжээний ажлын талаар

Аймгийн радио болон тоон телевизийн станцуудын ажиллагаанд хяналт тавьж гарсан гэмтэл саатлыг шуурхай засварлаж, өдөр бүр үзлэг үйлчилгээ хийсэн. Мөн сум, орон нутгийн тоон телевизийн тоног төхөөрөмжүүд гэмтсэн үед тухай бүр засварласан. Цахилгаан щит, автоматуудад үзлэг үйлчилгээ хийсэн болно.

5.6.4. Усны талаар

Цэвэрлэх байгууламжийн барилга байгууламжид хамгаалалтын зурвас, мөн эзэмшлийн газарт эрүүл ахуйн болон энгийн хамгаалалтын бүсийг шинээр тогтоох талаар холбогдох газарт албан бичиг хүргүүлэв.

Аймгийн Онцгой байдлын газарт байгууллагын салбар цехүүдийн галын аюулгүйн байдлын дүгнэлтийг гаргуулж, байгууллагын гамшгийн төлөвлөгөөг боловсруулан батлуулсан.

Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн МХГ-ын өгсөн зөвлөмжийн дагуу тус компани бүх объектод ариутгал халдваргүйтгэл хийж, орчны тойронд их цэвэрлэгээ хийж гүйцэтгэв.

Аймгийн Авто тээврийн төвийн үйлчилгээний газрын цэвэр усны гол магистрал шугам хөлдсөнийг гэсгээж шугамыг хэвийн болгов.

Айл өрх болон орон сууцны хэрэглэгчдээс дотор болон гадна бохир усны шугам бөглөрсөн дуудлага 20, бохир усны шугамын гэмтэл засварын дуудлага 2, гадна усны шугам хөлдсөн дуудлага 4, бохир усны цооногийн бохир усыг нь төлбөртэй соруулах дуудлага 2 нийтдээ 28 дуудлага ирүүлснийг бүрэн барагдуулж ажилласан.

Ундны усны тогтоогдсон цэгүүдээс дээж авч химийн шинжилгээ хийв.

5.6.5. Авто тээврийн чиглэлээр

2020 оны эхнээс өссөн дүнгээр техникийн хяналтын үзлэгт нийт 353 тээврийн хэрэгсэл хамрагдав. Үүнд суудлын тэрэг 221, ачааны тэрэг 57, автобус 6, тусгай 6, механизм 21, зүтгүүр 3, чиргүүл 8, Мотоцикль 29, Цистерн 2 тус тус хамрагдсан.

Өлгий-Улаанбаатарын чиглэлд 2-р сард нийт 23 рейсээр 436 зорчигчийг тээвэрлэсэн.

Өдөр бүр орон нутгийн зорчигчдын тээврийн хэрэгсэлд хяналт тавьж бүртгэл гарган ажиллав.

Энэ сард улс хоорондын чиглэлд 4 рейс 83 иргэнийг тээвэрлэсэн болно.

5.6.6. Нисэх буудлын үйл ажиллагааны талаар

2020 оны 2 дугаар сарын 1-нээс 2 дугаар сарын 29-нийг хүртэл нийт 42 агаарын хөлөг хүлээж авснаас “Хүннү-Эйр” ХХК-ийн 25 рейсийн агаарын хөлгөөр 262 том хүн, хагас зардал 25 амь даатгал 17, ачаа 409 ш, гар тээш 315 ш, 5 ширхэг шуудан, “Аэро-Монголиа” ХХК-ийн 25 рейсийн агаарын хөлгөөр 75 том хүн, хагас зардал 3, амь даатгал 10, ачаа 113 ш, гар тээш 91 ш, 10 ширхэг шуудан, Нийт 337 нийт зорчигч, хагас зардал 28, амь даатгал 27, 522 ш нийт ачаа, гар тээш 406 ш, 15ш шуудан тус тус тээвэрлэсэн.

Нисэх буудлын ажилчдыг давхардсан тоогоор 512 удаа, ажилчдын гар тээш 25 ширхгийг аюулгүй байдлын үзлэгт хамруулав. Нэг удаагийн үнэмлэхийг 6 хүнд өгөв.

Өдөр бүрийн бэлэн байдлын мэдээг цаг тухайд нь явуулж байв. Бүх тоног төхөөрөмжүүдэд үзлэг үйлчилгээ хийж ямар нэгэн сааталгүй ажилласан болно.

2-р сарын нислэгийн тоо:

№	Авиа компани	Агаарын хөлгийн маяг	Нислэгийн тоо
1	Аэро-Монголиа	ER 145	17
2	Хүннүү-Эйр	ATR-72 / ERJ160	25
Нийт			42

БНХАУ-д гарсан шинэ төрлийн коронавирусийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Засгийн газрын 2020 оны 39 дүгээр тогтоол, 2020 оны “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 62 дугаар тогтоол, Зам, тээврийн хөгжлийн Сайдын 2020 оны А/44 дүгээр тушаал, 2020 оны А/48 дугаар тушаал зэрэг улсын хэмжээнд болон зам тээврийн салбарт тусгайлан өгөгдсөн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх, бэлэн байдлыг ханган ажиллах үүргийн дагуу 2020 оны 2 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн өндөржүүлсэн бэлэн байдалд шилжин ажиллаж байна.

Тус вирусийн халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлж, ирсэн зорчигчдын биеийн байдал болон биеийн халууныг аймгийн Нэгдсэн эмнэлэг болон “Шипагер” ӨЭМТөвтэй хамтран тогтмол хэмжиж, үзлэгт оруулж, НБҮГ-аас ирсэн маягтын дагуу нислэгтэй өдөр зорчигчдын мэдээллийг бүрэн бөглөж аймгийн ОБГ, НБҮГ-т тогтмол мэдээлэл хүргүүлж байна.

2020 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн “Хүннү-Эйр” ХХК-ийн Улаанбаатар-Баян-Өлгий чиглэлийн MML 181-р онгоцонд 27 зорчигч байснаас 4 нь Вьетнам улсын иргэн, 1 нь Тайланд болон БНСУ-аас ирж буй Монгол улсын иргэн байсан ба ирж буй зорчигчдыг онгоц газардахаас өмнө онгоцны үйлчлэгч нь биеийн халууныг хэмжихэд Вьетнам улсын нэг иргэн 37.7 халуунтай байна гэсэн мэдээллийг орон нутгийн цагаар

16:31 минутад нислэгийн удирдагчид мэдээлэл өгч аймгийн ЭМГ, МХГ, ОБГ-тай хамтарч аймгийн Онцгой комисст /шуурхай штаб/-д бүдүүвч схемийн дагуу шуурхай мэдэгдсэн.

Агаарын хөлөг 16:44 цагт Баян-Өлгий аймгийн Өлгий нисэх буудалд газардсан. Аймгийн онцгой комисс, мэргэжлийн байгууллагуудын өгсөн үүргийн дагуу ирсэн зорчигчдыг ирэх танхимд тусгаарлаж сэжиг бүхий 5 иргэнийг тусгаарлах өрөөнд оруулсан ба орон нутгийн цагаар 20:00 цагт аймгийн Нэгдсэн эмнэлэгт тусгаарлахаар авч явсан.

ТАВ. СУМ, ОРОН НУТГИЙН ТАЛААР

1. АЛТАЙ СУМ

Дэлхий даяар Шинэ коронавирусын дэгдэлт эрчимтэй байгаатай холбогдуулан Сумын Засаг даргын “Урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай” А/13 дугаар захирамжийн дагуу байгууллагуудад байнгын хяналт тавьж ажиллаж байна.

Мөн сумын Засаг даргын “Сар бүр нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулах тухай А/21, “Албан байгууллага, аж ахуйн нэгж, айл, өрхүүдийн орчинд их цэвэрлэгээ хийлгэх тухай” А/24 дүгээр захирамжийн дагуу 5 дахь өдөр болгон орчин тойронд их цэвэрлэгээ хийж хэвшсэн.

2 дугаар сард сумын Засаг даргын захирамжаар Онцгой комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулж, шинэ төрлийн коронавирусээс урьдчилан сэргийлэх талаар хурал хийж, Засаг даргын “Шуурхай штаб байгуулах тухай” А/23 дугаар захирамжийг гарган хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын 2019 оны А\846 тоот захирамжийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд Агаар бохирдуулах эх үүсвэрийн улсын нэгдсэн тооллогыг тус суманд шинэчлэгдсэн журмын дагуу чанартай зохион явуулж тооллогын дүнг аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс болон аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт хүргүүлэв.

2. САГСАЙ СУМ

Сумын Засаг дарга аймгийн Засаг даргатай байгуулсан 2019 оны үр дүнгийн гэрээг дүгнүүлж, 2020 оны гэрээг байгууллаа.

Тус сум аймагтаа нэгтгэсэн үнэлгээгээр 2-р байранд шалгарлаа.

Засгийн газрын 2020 оны “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 62 дугаар тогтоол, Улсын Онцгой Комиссын даргын 2020 оны “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” удирдамж, аймгийн Засаг дарга, аймгийн Онцгой комиссын даргын 2020 оны А/44, А/61, А/84, А/89, А/96, А/113, А/118 дугаар захирамж, аймгийн Засаг дарга, аймгийн Онцгой комиссын даргын 2020 оны 2 албан даалгавар, Шинэ коронавирус /КОВИД -19 өвчин/ -аас урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлын хүрээнд суманд холбогдох арга хэмжээг цаг алдалгүй хэрэгжүүлэн ажиллаж байна.

Засгийн газрын холбогдох тогтоолын дагуу Төсвийн байгууллагууд батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг шинэчлэн тогтоолоо.

Сумын Засаг даргын 2019 оны А/132 дугаар захирамжийн дагуу 18-50 насны эрчүүдийн дунд цэргийн тоо бүртгэлийн ажлыг зохион байгуулж мэдээг Цэргийн штабт хүргүүлэв.

Шинэ коронавирус /КОВИД -19 өвчин/ -аас урьдчилан сэргийлэх, хамгаалах хүрээнд гарсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Улсын Онцгой комиссын шийдвэр, аймаг, сумын Засаг даргын захирамж, албан даалгавар, аймгийн Онцгой комиссын шийдвэрийн сум, орон нутаг дахь хэрэгжилтийг хангах хүрээнд Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэгийн багш, ажилтнууд хяналтын цэг, Шуурхай штабт үүрэг гүйцэтгэж байна.

3. ЦАГААННУУР ТОСГОН

Шинэ төрлийн коронавирусээс урьдчилан сэргийлэх тухай Засгийн газрын тогтоол, шийдвэр, аймгийн Онцгой комиссын шийдвэр, Засаг даргын захирамж, албан даалгаврын хэрэгжилтийг хангуулах талаар Шуурхай штаб байгуулан, эргүүл жижүүр 24 цагаар томилон холбогдох арга хэмжээ авч ажиллаж байна.

Цэргийн тоо бүртгэлийн 2019 оны тайланг 2 дугаар сарын 12 нд хуваарийн дагуу тушаав.

Ерөнхий боловсролын сургууль болон Хүүхдийн цэцэрлэг хорио цээрийн дэглэмийн улмаас амарч байгаа болно.

Томуу, томуу төст өвчний үед гараа тогтмол угаах, олон нийтийн газраар бага насны хүүхдийг дагуулж явахгүй байх, амны хаалт зүүж хэвшүүлэх, ханиаж найтаахдаа амаа алчуураар дарах зэрэг зөвлөгөө, зөвлөмжийг олон нийтэд хүргэн ажиллаж байна.